

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгоны ерөнхий боловсролын сургуулийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2022/132-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn
Сүхбаатар сум
2022 он

ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК

Утас: 99102291 Цахим хаяг: Nitsbalance@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт.....	18
4.1 Зөвлөмж.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
БШУЯ	Боловсрол Шинжлэх Ухааны Яам



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № 107 2022/132-НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-г

МАНДАЛ СУМЫН ТҮНХЭЛ ТОСГОНЫ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Д.ЭНХТУЯА
ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгоны сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгоны сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	30,814,738.53	12,268,809.16
35	БАРАА МАТЕРИАЛ	30,814,738.53	12,268,809.16
35100	Түүхий эд материал	14,082,158.65	5,542,220.00
35110	Тусгай зориулалттай материал	14,082,158.65	5,535,820.00
35130	Эм боох материал	0.00	6,400.00
35400	Хангамжийн материал	16,732,579.88	6,726,589.16
35410	Бичиг хэргийн материал	309,350.00	227,050.00
35420	Аж ахуйн материал	3,330,900.00	470,850.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,212,500.00	0.00
35450	Барилгын засварын материал	2,385,200.00	1,319,200.00
35460	Хүнсний материал	61,600.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	7,433,029.88	4,709,489.16
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	534,832,518.63	967,214,226.49
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	534,832,518.63	967,214,226.49
39200	Биет хөрөнгө	497,158,319.91	929,559,902.77
39201	Барилга, байгууламж, орон сууц	356,053,829.25	809,053,829.25
39202	Хуримтлагдсан элэгдэл	-49,723,333.14	-72,164,734.86
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,562,500.00	14,562,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-10,404,166.92	-11,860,416.96
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	169,519,583.09	163,639,286.49
39206	Хуримтлагдсан элэгдэл	-110,269,242.71	-101,540,581.12
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	107,655,155.07	95,461,991.15
39208	Хуримтлагдсан элэгдэл	-47,962,710.30	-42,954,005.57
39214	Бусад үндсэн хөрөнгө	42,339,105.00	54,228,105.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-16,579,051.62	-20,300,989.74
39217	Ном	41,966,652.19	41,434,919.13
39300	Биет бус хөрөнгө	37,674,198.72	37,654,323.72
39301	Программ хангамж	318,000.00	318,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-143,801.28	-163,676.28
39303	Бусад биет бус хөрөнгө	37,500,000.00	37,500,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	565,647,257.16	979,483,035.65
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	565,647,257.16	979,483,035.65
51	Засгийн газрын хувь оролцоо	565,647,257.16	979,483,035.65
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	407,571,022.70	407,571,022.70
51200	Хуримтлагдсан үр дүн	-222,723,368.44	194,324,923.61
51210	Өмнөх үеийн үр дүн	-225,854,179.49	-221,625,711.88
51220	Тайлант үеийн үр дүн	3,130,811.05	415,950,635.49
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	380,799,602.90	377,587,089.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	565,647,257.16	979,483,035.65

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	797,603,512.22	1,231,890,339.43
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	48,326,882.09	478,520,707.30
120	Нийтлэг татварын бус орлого	48,326,882.09	478,520,707.30
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	42,524,221.41	474,957,159.02
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	5,802,660.68	3,563,548.28
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	749,276,630.13	753,369,632.13
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	697,972,400.00	676,184,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	697,972,400.00	676,184,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	19,225,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	10,759,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	8,466,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	51,304,230.13	57,960,132.13
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	51,304,230.13	57,960,132.13
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	794,472,701.17	813,048,887.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	794,472,701.17	813,048,887.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	750,239,170.60	770,365,230.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	558,791,993.33	538,925,155.72
210101	Үндсэн цалин	342,329,461.03	388,487,949.72
210102	Нэмэгдэл	171,990,595.34	117,639,697.00
210104	Урамшуулал	44,471,936.96	32,797,509.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,644,926.10	71,236,536.54
210201	Тэтгэврийн даатгал	48,324,863.21	50,755,458.14
210202	Тэтгэмжийн даатгал	5,669,712.97	5,237,019.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,475,290.38	4,135,915.64
210204	Ажилгүйдлийн даатгал	1,103,670.56	1,009,876.63
210205	Эрүүл мэндийн даатгал	11,071,388.98	10,098,266.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,635,530.13	57,514,532.13
210301	Гэрэл, цахилгаан	4,351,341.60	4,430,858.45
210302	Түлш, халаалт	44,633,088.53	52,603,673.68
210303	Цэвэр, бохир ус	1,651,100.00	480,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,114,872.80	16,269,982.00
210401	Бичиг хэрэг	1,106,400.00	1,363,100.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	409,400.00	976,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	716,800.00	955,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,758,272.80	12,098,882.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0.00	76,000.00
210408	Бараа материал акталсны зардал	3,624,000.00	0.00

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2105	Нормативт зардал	3,344,870.00	2,251,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	247,650.00	193,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,097,220.00	2,058,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,143,400.00	2,908,100.00
210604	Урсгал засвар	1,143,400.00	2,908,100.00
2107	Томилолт, зочны зардал	170,900.00	301,500.00
210702	Дотоод албан томилолт	170,900.00	301,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,594,500.00	12,337,430.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	912,500.00	11,473,430.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	864,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,250,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,798,178.24	68,620,993.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	828,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,676,075.45	10,647,458.65
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	50,294,102.79	57,973,535.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,233,530.57	42,683,657.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,513,000.00	18,725,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,813,000.00	18,225,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	500,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,720,530.57	23,958,657.74
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,720,530.57	23,958,657.74
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	3,130,811.05	418,841,451.49
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	2,890,816.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	2,890,816.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	3,130,811.05	415,950,635.49

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	407,571,022.70	380,799,602.90	-225,854,179.49	562,516,446.11
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	407,571,022.70	380,799,602.90	-225,854,179.49	562,516,446.11
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	3,130,811.05	3,130,811.05

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	407,571,022.70	380,799,602.90	-222,723,368.44	565,647,257.16
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	407,571,022.70	380,799,602.90	-222,723,368.44	565,647,257.16
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	1,097,656.56	1,097,656.56
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	407,571,022.70	380,799,602.90	-221,625,711.88	566,744,913.72
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-3,212,513.56	0.00	-3,212,513.56
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	415,950,635.49	415,950,635.49
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	407,571,022.70	377,587,089.34	194,324,923.61	979,483,035.65

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	752,396,130.13	756,196,232.13
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	752,396,130.13	756,196,232.13
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	697,972,400.00	676,184,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	697,972,400.00	676,184,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,119,500.00	22,052,100.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	10,759,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	8,466,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,119,500.00	2,826,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	51,304,230.13	57,960,132.13
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	51,304,230.13	57,960,132.13
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	741,781,330.13	737,907,332.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	741,781,330.13	737,907,332.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	694,960,099.56	692,458,674.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	558,791,993.33	538,925,155.72
210101	Үндсэн цалин	342,329,461.03	388,487,949.72
210102	Нэмэгдэл	171,990,595.34	117,639,697.00
210104	Урамшуулал	44,471,936.96	32,797,509.00

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,644,926.10	71,236,536.54
210201	Тэтгэврийн даатгал	48,324,863.21	50,755,458.14
210202	Тэтгэмжийн даатгал	5,669,712.97	5,237,019.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,475,290.38	4,135,915.64
210204	Ажилгүйдлийн даатгал	1,103,670.56	1,009,876.63
210205	Эрүүл мэндийн даатгал	11,071,388.98	10,098,266.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,635,530.13	57,514,532.13
210301	Гэрэл, цахилгаан	4,351,341.60	4,430,858.45
210302	Түлш, халаалт	44,633,088.53	52,603,673.68
210303	Цэвэр, бохир ус	1,651,100.00	480,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,771,450.00	3,635,800.00
210401	Бичиг хэрэг	436,000.00	775,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	409,400.00	976,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,714,050.00	356,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,712,000.00	728,000.00
2105	Нормативт зардал	966,800.00	996,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	194,800.00	199,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	772,000.00	797,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,540,700.00	1,835,100.00
210604	Урсгал засвар	1,540,700.00	1,835,100.00
2107	Томилолт, зочны зардал	170,900.00	301,500.00
210702	Дотоод албан томилолт	170,900.00	301,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,794,500.00	15,696,450.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,112,500.00	14,832,450.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	864,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,250,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,643,300.00	2,316,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	880,700.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,762,600.00	2,316,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,821,230.57	45,448,657.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,981,200.00	18,663,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,281,200.00	18,163,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,119,500.00	2,826,600.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,119,500.00	2,826,600.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,720,530.57	23,958,657.74
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,720,530.57	23,958,657.74
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	10,614,800.00	18,288,900.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	10,614,800.00	18,288,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,614,800.00	18,288,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,614,800.00	18,288,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,614,800.00	18,288,900.00

VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-10,614,800.00	-18,288,900.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	741,096,300.00	710,185,474.39	30,910,825.61	95.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	741,096,300.00	710,185,474.39	30,910,825.61	95.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	719,390,300.00	691,522,074.39	27,868,225.61	96.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	553,288,600.00	538,925,155.72	14,363,444.28	97.4
210101	Үндсэн цалин	395,005,700.00	388,487,949.72	6,517,750.28	98.3
210102	Нэмэгдэл	127,139,700.00	117,639,697.00	9,500,003.00	92.5
210104	Урамшуулал	31,143,200.00	32,797,509.00	-1,654,309.00	105.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,433,000.00	71,236,536.54	6,196,463.46	92.0
210201	Тэтгэврийн даатгал	55,301,400.00	50,755,458.14	4,545,941.86	91.7
210202	Тэтгэмжийн даатгал	5,532,900.00	5,237,019.51	295,880.49	94.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,426,300.00	4,135,915.64	290,384.36	93.4
210204	Ажилгүйдлийн даатгал	1,106,600.00	1,009,876.63	96,723.37	91.2
210205	Эрүүл мэндийн даатгал	11,065,800.00	10,098,266.62	967,533.38	91.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,466,700.00	57,514,532.13	6,952,167.87	89.2
210301	Гэрэл, цахилгаан	7,516,100.00	4,430,858.45	3,085,241.55	58.9
210302	Түлш, халаалт	55,137,400.00	52,603,673.68	2,533,726.32	95.4
210303	Цэвэр, бохир ус	1,813,200.00	480,000.00	1,333,200.00	26.4
2104	Хангамж, бараа материалын зардал	4,097,600.00	3,773,700.00	323,900.00	92.1
210401	Бичиг хэрэг	446,100.00	446,000.00	100.00	99.9
210402	Тээвэр, шатахуун	800,000.00	800,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,299,600.00	976,800.00	322,800.00	75.1
210404	Ном, хэвлэл	603,900.00	603,900.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	219,200.00	219,000.00	200.00	99.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	728,800.00	728,000.00	800.00	99.8
2105	Нормативт зардал	996,800.00	996,800.00	0.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	199,400.00	199,400.00	0.00	100.0

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	797,400.00	797,400.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,977,000.00	13,945,600.00	31,400.00	99.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,000,000.00	12,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	1,977,000.00	1,945,600.00	31,400.00	98.4
2107	Томилолт, зочны зардал	301,500.00	301,500.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилолт	301,500.00	301,500.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,002,300.00	2,001,450.00	850.00	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,138,300.00	1,137,450.00	850.00	99.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	864,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,826,800.00	2,826,800.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,826,800.00	2,826,800.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,706,000.00	18,663,400.00	3,042,600.00	85.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,706,000.00	18,663,400.00	3,042,600.00	85.9
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,206,000.00	18,163,400.00	3,042,600.00	85.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00	0.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	741,096,300.00	710,185,474.39	30,910,825.61	95.8
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	676,184,000.00	652,225,342.26	23,958,657.74	96.4
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	676,184,000.00	652,225,342.26	23,958,657.74	96.4
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	64,912,300.00	57,960,132.13	6,952,167.87	89.2
320001	Орон нутгийн төсвөөс	64,912,300.00	57,960,132.13	6,952,167.87	89.2
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	712.00	712.00		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00		
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00		
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	47.00	47.00		
620001	Удирдах ажилтан	4.00	4.00		
620002	Гүйцэтгэх ажилтан	34.00	30.00		
620003	Үйлчлэх ажилтан	9.00	13.00		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,052,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,052,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,052,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	466,000.00
210401	Бичиг хэрэг	329,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	137,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	329,500.00
210604	Урсгал засвар	329,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,430,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,430,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,826,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,826,600.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,826,600.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	22,052,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	22,052,100.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	10,759,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,466,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,826,600.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгоны ерөнхий боловсролын сургуулийн /цаашид Мандал сумын Түнхэл тосгоны ерөнхий боловсролын сургууль гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримтын бүрдүүлэлт, бараа материалын ангилалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Эн Ай Ти Эс баланс аудит” ХХК-ийн аудитор Ч.Ганчулуун гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер И.Туяа, захирал Ш.Ичинхорлоо, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын, аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын Түнхэл тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Эн Ай Ти Эс баланс аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мандал сумын Түнхэл тосгоны ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Хүүхэд бүрийн сурлагын ахиц амжилтыг ахиулж, багш нарын бүх талын мэдлэг, ур чадварыг хөгжүүлж, сурч хөгжих эрүүл таатай орчинг бүрдүүлж ажиллана” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сурагчдын сурлагын хоцрогдлыг бууруулах, сургалтыг тэгш хүртээмжтэй хүргэх
- Багш ээлжит хичээлийн бэлтгэлийг сургалтын хэлбэрээс үл хамааран чанартай бэлтгэж, үр дүнтэй хэрэгжүүлэх
- Багшийн хөгжлийг дэмжиж, багш бүр заах ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх
- Сурагчдад мэргэжлээ зөв сонгох нь дэмжлэг туслалцаа үзүүлж, сонгон хичээлүүд болон ЭЕШ-д чанартай бэлтгэх
- Сурагчдын эрүүл аюулгүй орчинд сурч хөгжих нөхцөлийг ханган эцэг эх, багш сурагчидтай хамтран ажиллаж үр дүнг тооцох

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д: “Нягтлан бодогч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөж ажиллана”; /2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/
- ЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор баталсан “Ковид 19” цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай”;

- ЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 267 дугаар тушаалаар баталсан “Цахилгаан, дулааны уурын хангамж, хэрэглээг зохицуулах тухай”
- Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын хамтарсан тушаал “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” журам тайланд онд шинээр мөрдөгдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж дүгнэж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 оны 9 дүгээр сард тус сургуулийн 2019-2020 санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийсэн байна. Хяналт шалгалтаар шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь мэдээлэх, баримт материалыг архивын стандартын дагуу үдэх, санхүүгийн тайлангийн тодруулгыг иж бүрэн хийх зэрэг зөвлөмжүүд хүргүүлснийг хэрэгжүүлж ажилласан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын Түнхэл тосгоны ерөнхий боловсролын сургууль 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 811,884.0 мянган төгрөгийн 2.0 хувиар буюу 16,237.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 11,366.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мандал сумын Түнхэл тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 413,835.8 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	30,814.7	12,268.8	-18,545.9
Үндсэн хөрөнгө	534,832.5	967,214.2	432,381.7
Нийт хөрөнгө	565,647.2	979,483.0	413,835.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	565,647.2	979,483.0	413,835.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	565,647.2	979,483.0	413,835.8

Бараа материалын дансны үлдэгдэл 12,268.8 мянган төгрөг болж 18,545.9 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны үлдэгдлээс зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,216,198.6 мянган төгрөг / анхны өртгөөр / болж 446,283.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 18,288.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ном худалдан авсан болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 453,000.0 мянган төгрөгийн сургуулийн их засварын ажлыг капиталжуулсан, БШУЯ-наас 6,676.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 190.3 мянган төгрөгийн самбар, 1,755.2 мянган төгрөгийн ном, төгсөгчид болон эцэг эхчүүдийн хандиваар 11,889.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч бүртгэлд тусган, Мандал сумын ИТХ-ын 2021 оны 139 дугаар тогтоолоор 45,515.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж данснаас хассанаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 979,483.0 мянган төгрөг болж 413,835.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Мандал сумын Түнхэл тосгоны ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 419,717.9 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоос шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 17,320.2 мянган төгрөгөөр өссөн нь бараа үйлчилгээний зардал өссөнөөс шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 871,346.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 130,250.2 мянган төгрөгөөр бууруулж 741,096.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр **741,096.3** мянган төгрөгийн төсөв баталснаас 676,184.0 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, орон нутгийн төсвөөс 64,912.3 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 676,184.0 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 57,960.1 мянган төгрөгийн нийт 710,185.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 710,185.5 мянган төгрөгийг зарцуулан, 23,958.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **710,185.5** мянган төгрөг буюу 95.8 хувьтай байгаа нь бараа, ажил үйлчилгээний зардлыг 27,868.2 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийг 3,042.6 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд “Боловсролын Чанарын Шинэчлэл” төслөөс 8,000.0 мянган төгрөг, БСГ-аас үнэлгээний шалгалтын бичиг хэргийн зардлын санхүүжилт 329.0 мянган төгрөг, ариутгалын зардлын санхүүжилт 137.0 мянган төгрөг, сурах бичиг түрээсийн номны орлого 2,826.6 мянган төгрөг, төгсөгчдийн хандиваас 10,759.5 мянган төгрөг нийт 22,052.1 мянган төгрөгийн орлого төвлөрснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

1.БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай” тушаалын хоёрдугаар хавсралт “Коронавируст халдварын үед ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалт зохион байгуулахад мөрдөх түр журам”-ын дагуу хичээл сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

2. Тайлант онд Мандал сумын Түнхэл тосгоны ерөнхий боловсролын сургууль БШУЯ-наас хэрэгжүүлж буй “E-FIRST” төсөл арга хэмжээнд хамрагдаж, төслийн хүрээнд 8,000.00 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансанд хүлээн авч зарцуулсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 144 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Мандал сумын Түнхэл тосгоны ерөнхий боловсролын сургууль тайлант оны үйл ажиллагаанд 741,096.3 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 710,185.5 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 4.2 хувиар хэмнэсэн нь

ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 951.9 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгөгдсөнийг албан шаардлагыг бүрэн биелүүлж, шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг биелүүлээгүй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	1	951.9	1	951.9	100
Зөвлөмж	2		1		50
Нийт дүн	3	951.9	2	951.9	75.0

Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

2. Тайлант онд төлбөрийн баримтын цахим системд шивэгдсэн бараа материалын худалдан авалтад тус байгууллагад хамааралгүй 5,923.4 мянган төгрөгийн худалдан авалт илүү шивэгдсэн байгаа нь анхан шатны баримтгүй болон баримтын бүрдэлгүй орлого зарлагын гүйлгээг хүлээн зөвшөөрч данс бүртгэлд тусгах эрсдэлийг үүсгэж байна. Иймд төлбөрийн баримтын цахим системийг үнэн зөв хөтлөх, алдаатай эсвэл буруу шивэгдсэн баримтуудыг тухай бүр залруулж байх шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитын нийт 5,332.8 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс 2,114.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлж, 3,217.9 мянган төгрөгийн 2 алдаа, зөрчилд зөвлөмж өглөө.

4.1 Албан шаардлага

1. Өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөр үүсгэлгүйгээр НДШ-ийн шимтгэлийн зөрүүгийн өглөг гэж тайлант оны батлагдсан төсвөөс 2,114.9 мянган төгрөгийг төлсөн нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.3: “бүх өр төлбөр” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил гүйлгээг тухай бүр нь үнэн зөв бүртгэж, тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэх.

4.2 Зөвлөмж

1. Санхүүгийн тайлагналтай холбоотой

1.1 Илрүүлэлт: Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын дүнг бараа материал, үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн орлогын дүнгээс зөрүүтэй илэрхийлсэн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн заавар”-тай нийцээгүй бөгөөд “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж байх.

2. Төлбөрийн баримттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Тайлант онд 3,217.9 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах

бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгоны ерөнхий боловсролын сургууль	3	5,332.8			-	-	1	2,114.9	2	3,217.9

